

2024 оны “Төсвийн тухай хууль”-ийг дагалдан өргөн

барьсан татварын хуулиудад орох өөрчлөлтүүд



Холбоо барих

Серги Кобахидзе

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх Захирал
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Ахлах Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирын Энхсанаа

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhsanaa.erdene-ochr@pwc.com

**ПрайсвотэрхаусКүүпэрс
Такс ТМЗ ХХК**

Сентрал Тауэр, 6 давхар
601 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn

**1. Төсвийн хуулийг дагалдсан татварын хуулийн өөрчлөлтүүд**

Засгийн Газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдийн хамт Улсын Их Хуралд 2023 оны 10 дугаар сарын 2-нд өргөн барьсан. 2024 оны төсвийн хуулийг дагалдуулан татварын хуулиудад оруулахаар санал болгож буй гол өөрчлөлтүүдээс та бүхэнд танилцуулж байна.

**ХХОАТ болон ААНОАТ**

Хувь Хүний Орлогын Албан Татвар (ХХОАТ) болон Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар (ААНОАТ)-ын тухай хуульд дараах төрлүүдийн бизнесийн үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжих зорилготой өөрчлөлтүүдийг тус тус оруулахаар холбогдох хуулийн төслүүдийг бэлтгэсэн байна.

а) Засгийн газар, аймаг, нийслэл, оршин суугч татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч ба хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан үнэт цаасны хувьд:

- Оршин суугч бус татвар төлөгчийн дээрх үнэт цаасыг борлуулсны орлогод татвар ногдуулах дүнг тооцохдоо анх худалдан авсан дүнг хасаж тооцно (одоогийн хуулиар нийт дүнгээс тооцож байгаа);
- Дээрх үнэт цаасыг борлуулсны орлогод ногдох татварыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд суутган авч, төсөвт төлж, тайлагнана (одоогийн хуулиар өөрөө төлж, тайлагнахаар байгаа); болон
- Дээрх үнэт цаасыг борлуулсны орлогод ногдох татварыг дараах онуудад, дор дурдсан хувиар хөнгөлнө.

Орлогын төрөл	Татварын хөнгөлөлт	
	2024-2026	2027-2029
Засгийн газар, аймаг, нийслэл, оршин суугч татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч ба хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан үнэт цаасыг борлуулсны орлого	90%	50%

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2023 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.



б) Орон нутагт орон сууц барих, түрээслэх үйл ажиллагаа

- Борлуулалтын орлогод ногдох ААНОАТ-ыг дараах байдлаар хөнгөлнө:

Орлогын төрөл	Байршил	Татварын хөнгөлөлт	
		2024-2026	2027-2029
Орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлого	Багануур, Багахангай, Налайх дүүрэг, Дархан-Уул болон Орхон аймгийн төвийн сумын хилийн цэс дотор	50%	20%
	Бусад аймаг, сумын хилийн цэс дотор	90%	50%

- Орон сууц түрээсэлсний орлогод ногдох ААНОАТ, ХХОАТ-ыг дараах байдлаар тус тус хөнгөлнө:

Орлогын төрөл	Байршил	Татварын хөнгөлөлт	
		2024-2026	2027-2029
Нийтийн зориулалттай орон сууцны барилгад хүн амьдран суух зориулалтаар орон сууц түрээсэлсний орлого	Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг, сумын хилийн цэсийн дотор	90%	50%



Нэмэгдсэн Өртгийн Албан Татварын (НӨАТ)

Малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, хөөврийг НӨАТ-аас чөлөөлөхөөр заасан.



Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль

Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах замаар нэмүү өртөг шингэсэн ашигт малтмалын баяжмал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх техник, эдийн засгийн үндэслэл бүхий үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн хувьд НӨАТ-ыг төлөх хугацааг 4 жилээр сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.



Та дээрх сэдэв болон бусад асуудлаар зөвлөгөө авах бол бидэнтэй холбоо барина уу.

Төсвийн тухай” хуулийн төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол [энд дарна уу](#).

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2023 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.